

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ДУГААР 151021-24
ХАВСРАЛТ 13
ОГНОО 2022 оны 07-р сарын 19-ний өдөр

УТГА Их хэмжээний хэлцэл батлах тухай

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани") болон Компанийн 100 хувийн охин компани Сэнтрал Фүүдс ХХК-д шаардлагатай байгаа бизнесийн хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгийг Голомт Банк ХХК-иас зээл авах замаар шийдвэрлэх тухай их хэмжээний хэлцэлийг авч хэлэлцээд Компанийн Дүрмийн 9.4.18 дах заалт, Сэнтрал Фүүдс ХХК-ийн Дүрмийн 8.2, 9.1.25, 9.1.26 дах заалтууд болон Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн Аудитын хорооны зөвлөмжийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийг жилийн 15.76 (арван тав зууны далан зургаан) хувийн хүүтэй, 60 (жаран) сарын хугацаатай 10,000,000,000 (арван тэрбум) төгрөгийн бизнесийн хөрөнгө оруулалтын зээлийг Голомт Банк ХХК-иас авахыг зөвшөөрч холбогдох Зээлийн гэрээ (Хавсралт 1)-г Голомт Банк ХХК-тай байгуулах, гэрээнд Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг) болон Санхүүгийн газрын захирал (С.Дашдорж)-д олгосугай.
2. Компанийг жилийн 12 (арван хоёр) хувийн хүүтэй, 12 (арван хоёр) сарын хугацаатай 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөгийн ажлын капиталын зээлийг Голомт Банк ХХК-иас авахыг зөвшөөрч холбогдох Зээлийн гэрээ (Хавсралт 2)-г Голомт Банк ХХК-тай байгуулах, гэрээнд Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал болон Санхүүгийн газрын захиралд олгосугай.
3. Компанийг жилийн 4 (дөрвөн) хувийн хүүтэй, 18 (арван найман) сарын хугацаатай 2,000,000,000 (хоёр тэрбум) төгрөгийн Аккредитивийн санхүүжилтийн эрх (Хавсралт 3)-ийг Голомт Банк ХХК-тай байгуулахыг зөвшөөрч, гэрээнд Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал болон Санхүүгийн газрын захиралд олгосугай.
4. Сэнтрал Фүүдс ХХК-ийн Голомт Банк ХХК-аас авсан 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөгийн зээлийг жилийн 10 (арван) хувийн хүүтэй, 33 (гучин гурван) сарын хугацаатай 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөгийн репо санхүүжилтийн зээлээр дахин санхүүжүүлэхийг зөвшөөрч холбогдох Зээлийн гэрээ (Хавсралт 4)-г Голомт Банк ХХК-тай байгуулах, гэрээнд Сэнтрал Фүүдс ХХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Д.Жүгдэрнамжил) болон Үйл ажиллагаа дэмжих газрын захирал (Б.Бат-Ирээдүй)-д олгосугай.
5. Сэнтрал Фүүдс ХХК-ийн Голомт Банк ХХК-тай байгуулсан 2020 оны 05-р сарын 13-ны өдрийн ЗГ8125101138 тоот Зээлийн гэрээ болон 2021 оны 09-р сарын 09-ний өдрийн ЗГ8125101663 тоот Зээлийн гэрээний зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт

ДУГААР 151021-24
огноо 2022 оны 07-р сарын 19-ний өдөр

оруулахыг зөвшөөрч холбогдох Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээнүүд (Хавсралт 5-6)-ийг Голомт Банк ХХК-тай байгуулах, гэрээнд Сэнтрал Фүүдс ХХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Д.Жүгдэрнамжил)-д олгосугай.

6. Тогтоолын 1-5-д дурдсан зээлийн барьцаанд Хавсралт 7-д дурдсан Компанийн болон Сэнтрал Фүүдс ХХК-ийн эд хөрөнгийг барьцаалахыг зөвшөөрч холбогдох барьцааны гэрээнүүд (Хавсралт 8-13)-ийг Голомт Банк ХХК-тай байгуулах, гэрээнд Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал болон Санхүүгийн газрын захиралд, Сэнтрал Фүүдс ХХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Сэнтрал Фүүдс ХХК-ийн Гүйцэтгэх захиралд тус тус олгосугай.
7. Компанийн Голомт Банк ХХК-иас авах зээлд батлан даагчаар Компанийн нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд болох Премиум Групп ХХК-ийг оролцохыг зөвшөөрсүгэй.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

ДУГААР 151021-24
ОГНОО 2022.07.19

		ЗӨВШӨӨРСӨН	ТАТГАЛЗСАН	ТҮДГЭЛЗСЭН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	А.ГАНХУЯГ	 		
	ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:		А.ГАНБОЛД	
	О.БАТМӨНХ			
	Г.БАТ-ЭРДЭНЭ			
	Г.ЧИНЗОРИГ			
	Б.БАТ-ЭРДЭНЭ			
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:	Н.ЭНХБОЛД			
	В.ГАНЗОРИГ			
	ГАРИ СТИВЕН БИОНДО			
ТОГТООЛЫН БАТЛАГДСАН ХУВЬ:		100%		